# ХЭНТИЙ АЙМГИЙН
# БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 12 өдөр Дугаар А/34 Эг

Мал амьтны шимэгчтэх өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг, Аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн А/15 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх 2025 оны төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар батлагсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулахыг Баянбараат Хайрхан ХХК-ийн захирал (Т.Бямбадорж), Шүтээн дэнж ХХК-ийн захирал (Б.Мягмаржав) Өглөгч сүрэг ХХК-ийн захирал (Ц.Ариунболд) нарт даалгасугай.

3. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч /Ж.Ундрах/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.АЛТАНГЭРЭЛ

232501067

Сумын Засаг даргын 2025 оны 03-р сарын
12-ны өдрийн А/134 тоот захирамжийн хавсралт

## БАТШИРЭЭТ СУМЫН 2025 ОНЫ ПАРАЗИТТАХ ӨВЧНӨӨС ЭМЧЛЭН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ХАМРУУЛАХ МАЛ, АМЬТНЫ ТОО

| № | МЭҮНэгжийн нэр | Угаалга /мян.тол/ | | | | Туулгалт /мян.тол/ | | | | | Боловсруулалт /мян.тол/ | | | | Гуурын боловсруулалт хавар, намар /мян.тол/ | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үхэр | хонь | ямаа | бүгд | үхэр | хонь | ямаа | нохой | бүгд | үхэр | хонь | ямаа | бүгд | Үхэр | |
| 1 | Баянбараат хайрхан ХХК | 0.7 | 1.0 | 0.5 | **2.2** | 0.2 | | | 0.1 | **0.3** | 2.0 | | | **2.0** | **3.0** | **31.9** |
| 2 | Шүтээн дэнж ХХК | 0.7 | | | **0.7** | 0.2 | | | 0.1 | **0.3** | 2.0 | | | **2.0** | **3.0** | **9.6** |
| 3 | Өглөгч сүрэг ХХК | 0.6 | 7.0 | 1.5 | **9.1** | | 5.9 | 3.3 | | **9.2** | 1.0 | 4.3 | 2.4 | **8.7** | **2.0** | **29.0** |
| **дүн** | | **2.0** | **8.0** | **2.0** | **12.0** | **0.4** | **5.9** | **3.3** | **0.2** | **9.8** | **5.0** | **4.3** | **2.4** | **11.7** | **8.0** | **41.5** |

МАЛ ЭМНЭЛГИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Ж.УНДРАХ

2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр